

**ӨРГӨН НЭВТРҮҮЛГИЙН ТЕЛЕВИЗҮҮДЭЭР 2023 ОНЫ 2 ДУГААР УЛИРАЛД  
НЭВТРҮҮЛСЭН ҮНДЭСНИЙ ТҮҮХ, СОЁЛ, УЛАМЖЛАЛ, ТАНИН МЭДЭХҮЙН  
НЭВТРҮҮЛГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН ДҮГНЭЛТ**

Өргөн нэвтрүүлгийн тухай хууль, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2021 оны 01 тоот тогтоолоор батлагдсан “Телевизийн хөтөлбөрт тавигдах шаардлага”-аар өргөн нэвтрүүлгийн телевиз нь жилд 200 цагаас багагүй үндэсний түүх, соёл, уламжлалын нэвтрүүлэг бэлтгэн нэвтрүүлэх үүрэг хүлээлгэдэг. Зохицуулах хорооноос телевизүүдийн хөтөлбөрт хийдэг байнгын хяналт, мониторингийн тайланд үндэслэн улирал тутам энэхүү үүргийн хэрэгжилтийн байдалд үнэлгээ дүгнэлт гарган ажиллаж байна.

Улаанбаатар хотын өргөн нэвтрүүлгийн телевизүүдээр үндэсний түүх, соёл, уламжлалын нэвтрүүлэг нэвтрүүлсэн байдал 2023 оны 2 дугаар улирлын дүнгээр дараах байдалтай байна.

**Өргөн нэвтрүүлгийн телевизүүдийн үндэсний түүх, соёл, уламжлалын  
нэвтрүүлэг нэвтрүүлсэн байдал**

(2023 оны 4-6 дугаар сар)

Хүснэгт 1

Телевизийн нэр	2023 он 4 сар	2023 он 5 сар	2023 он 6 сар	2023 оны 2-р улирлын нийт дүн
Стар ТВ	20:36:17	36:56:57	64:22:20	121:55:34
ТВ8	20:31:37	25:13:36	27:26:47	73:12:00
Малчин ТВ	23:27:27	22:13:49	20:49:37	66:30:53
Сүлд	20:37:14	23:11:33	18:45:37	62:34:24
NTV	18:56:39	22:55:26	18:13:08	60:05:13
Central ТВ	20:11:23	17:54:53	20:38:19	58:44:35
ТВ5	10:42:19	18:43:21	25:35:22	55:01:02
Монгол HD	18:00:13	11:53:36	22:57:14	52:51:03
ТМ	13:33:32	20:28:08	17:57:07	51:58:47
ТВ9	15:36:54	16:05:58	15:33:27	47:16:19
Боловсрол суваг	16:51:39	13:00:34	10:43:20	40:35:33
SBN	13:16:28	8:19:47	12:15:21	33:51:36
Тэнгэр ТВ	9:20:21	9:09:18	7:11:56	25:41:35
С1	2:44:26	1:22:48	3:22:15	7:29:29
25-р суваг	2:30:12	0:00:00	0:00:00	2:30:12
UBS	0:52:01	0:00:00	0:00:00	0:52:01
ЕТВ	0:00:00	0:00:00	0:00:00	0:00:00
Ийгл ньюс	0:00:00	0:00:00	0:00:00	0:00:00
<b>Нийт</b>	<b>227:48:42</b>	<b>247:29:44</b>	<b>285:51:50</b>	<b>761:10:16</b>

Өргөн нэвтрүүлгийн телевизүүд нь хөтөлбөрт тавигдах шаардлагын дагуу улиралд дунжаар 50 цаг орчим буюу түүнээс дээш цагийн үндэсний түүх, соёл, уламжлалын нэвтрүүлэг нэвтрүүлэхэд жилийн нийт дүнгээр 200 цагийн шаардлагыг хангах боломжтой гэж үзэж болох юм. Тиймээс Улаанбаатар хотын өргөн нэвтрүүлгийн 18 телевизийн 2023 оны 2 дугаар улиралд нэвтрүүлсэн үндэсний түүх, соёл, уламжлалын нэвтрүүлгийн нийт цагийг авч үзэхэд 50% нь шаардлага хангах хэмжээнд хүрэхүйц явцтай байна. Тухайлбал Стар, ТВ8, Малчин, Сүлд, NTV, Central, ТВ5, Монгол, ТМ телевизүүд үндэсний түүх, соёл, уламжлалын нэвтрүүлэг 50 цагаас дээш нэвтрүүлсэн байна. Харин С1, 25-р суваг, UBS, ЕТВ, Ийгл ньюс телевизүүд бүтэн улирлын

турш 10 хүрэхгүй цаг нэвтрүүлсэн явцтай байгааг цаашид нэмэгдүүлэхгүй бол жилийн эцсийн дүнгээр шаардлага хангах хэмжээнд хүрэхгүй гэж дүгнэхээр байна.

### Өргөн нэвтрүүлгийн телевизүүдийн үндэсний түүх, соёл, уламжлалын нэвтрүүлэг нэвтрүүлсэн байдал


(2023 оны 1, 2 дугаар улирлын байдлаар)

Хүснэгт 2

Телевизийн нэр	2023 оны 1-р улирал	2023 оны 2-р улирал	Нийт
Стар ТВ	47:37:39	121:55:34	169:33:13
TB8	85:22:01	73:12:00	158:34:01
NTV	73:56:19	60:05:13	134:01:32
Central ТВ	65:42:39	58:44:35	124:27:14
Сүлд	60:07:36	62:34:24	122:42:00
Малчин ТВ	54:43:19	66:30:53	121:14:12
Монгол HD	56:32:40	52:51:03	109:23:43
Боловсрол суваг	66:25:42	40:35:33	107:01:15
TB9	57:24:16	47:16:19	104:40:35
ТМ	44:32:40	51:58:47	96:31:27
SBN	27:24:17	33:51:36	61:15:53
Тэнгэр ТВ	32:37:17	25:41:35	58:18:52
TB5	2:15:37	55:01:02	57:16:39
ЕТВ	21:33:41	0:00:00	21:33:41
25-р суваг	17:08:35	2:30:12	19:38:47
C1	6:08:47	7:29:29	13:38:16
UBS	8:43:22	0:52:01	9:35:23
Ийгл ньюс	0:48:03	0:00:00	0:48:03
<b>Нийт</b>	<b>729:04:30</b>	<b>761:10:16</b>	<b>1490:14:46</b>

Өргөн нэвтрүүлгийн телевизүүдийн үндэсний түүх, соёл, уламжлалын нэвтрүүлгийн цагийг 2023 оны 1 болон 2 дугаар улирлаар нэгтгэн Хүснэгт 2-т үзүүллээ. 2023 оны хагас жилийн дүнгээр 50% нь шаардлага хангасан үзүүлэлттэй үзүүлсэн нь Стар, ТВ8, NTV, Central, Сүлд, Малчин, Монгол, Боловсрол, ТВ9 гэсэн 9 телевиз 100 цагаас дээш үндэсний түүх, соёл, уламжлалын нэвтрүүлэг нэвтрүүлсэн байна.

График 1




Дээрх График 2-т өргөн нэвтрүүлгийн телевизийн үндэсний түүх, соёл, уламжлалын нэвтрүүлэг нэвтрүүлсэн байдлыг 2023 оны 1 болон 2 дугаар улирлын дүнгээр телевиз тус бүрээр харьцуулан үзүүлээ. Графикаас харахад энэ оны 2 дугаар улиралд үндэсний түүх, соёл, уламжлалын нэвтрүүлэг нэвтрүүлсэн байдлаар Стар, Сүлд, Малчин, ТМ, SBN, ТВ5 телевизүүд 1 дүгээр улирлын дүнгээс өссөн үзүүлэлт үзүүлснээс Стар, ТВ5 телевизүүд харьцангуй өндөр өсөлт үзүүлсэн байна.

Өргөн нэвтрүүлгийн телевизүүдээр 2023 оны 2 дугаар улиралд нэвтрүүлсэн үндэсний түүх, соёл, уламжлалын нэвтрүүлгийн цагийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулан авч үзье.

**Өргөн нэвтрүүлгийн телевизүүдээр 2023 оны 2 дугаар улиралд нэвтрүүлсэн үндэсний түүх, соёл, уламжлалын нэвтрүүлгийн цагийг 2022 оны 2 дугаар улирлын цагтай харьцуулсан байдал**

Хүснэгт 3

Телевизийн нэр	2022 он 4 сар	2022 он 5 сар	2022 он 6 сар	2022 он 2-р улирал	2023 он 4 сар	2023 он 5 сар	2023 он 6 сар	2023 он 2-р улирал
Монгол HD	22:10:49	18:52:28	32:37:28	73:40:45	20:36:17	36:56:57	64:22:20	121:55:34
ТВ5	05:58:29	05:39:45	05:04:38	16:42:52	20:31:37	25:13:36	27:26:47	73:12:00
Ийгл ньюс	00:00:00	00:00:00	00:00:00	0:00:00	23:27:27	22:13:49	20:49:37	66:30:53
Стар ТВ	21:43:45	07:36:32	11:03:05	40:23:22	20:37:14	23:11:33	18:45:37	62:34:24
NTV	02:23:17	09:14:04	02:50:02	14:27:23	18:56:39	22:55:26	18:13:08	60:05:13
Central ТВ	32:00:32	24:23:21	23:06:46	79:30:39	20:11:23	17:54:53	20:38:19	58:44:35
Сүлд	23:48:45	17:15:00	24:33:28	65:37:13	10:42:19	18:43:21	25:35:22	55:01:02
Малчин ТВ	10:40:15	04:41:16	06:35:07	21:56:38	18:00:13	11:53:36	22:57:14	52:51:03
ТМ	04:18:02	04:32:37	07:13:27	16:04:06	13:33:32	20:28:08	17:57:07	51:58:47
ТВ8	09:38:12	13:35:42	18:40:37	41:54:31	15:36:54	16:05:58	15:33:27	47:16:19
TenGer	00:00:00	00:16:51	03:56:30	4:13:21	16:51:39	13:00:34	10:43:20	40:35:33
SBN	08:18:36	10:01:56	13:21:38	31:42:10	13:16:28	8:19:47	12:15:21	33:51:36
ТВ9	02:48:55	02:27:16	02:55:13	8:11:24	9:20:21	9:09:18	7:11:56	25:41:35
С1	00:00:00	01:26:49	00:45:30	2:12:19	2:44:26	1:22:48	3:22:15	7:29:29
25-р суваг	0:00:00	0:00:00	0:44:22	0:44:22	2:30:12	0:00:00	0:00:00	2:30:12
UBS	00:52:34	03:08:45	07:53:00	11:54:19	0:52:01	0:00:00	0:00:00	0:52:01
Боловсрол суваг	38:35:15	37:34:36	39:38:48	115:48:39	0:00:00	0:00:00	0:00:00	0:00:00
ETB	08:30:15	11:51:27	14:19:08	34:40:50	0:00:00	0:00:00	0:00:00	0:00:00
<b>Нийт</b>	<b>191:47:41</b>	<b>172:38:25</b>	<b>215:18:47</b>	<b>579:44:53</b>	<b>227:48:42</b>	<b>247:29:44</b>	<b>285:51:50</b>	<b>761:10:16</b>



Улаанбаатар хотын өргөн нэвтрүүлгийн 18 телевизээр үндэсний түүх, соёл, уламжлалын нэвтрүүлэг 2022 оны 2 дугаар улиралд 579 цаг, 2023 оны 2 дугаар улиралд 761 цаг тус тус нэвтрүүлсэн нь 31%-аар өссөн үзүүлэлттэй байна. Монгол, ТВ5, Ийгл ньюс, Стар, Стар, Малчин, ТМ, Тэнгэр телевизүүд үндэсний түүх, соёл, уламжлалын нэвтрүүлэг бэлтгэн хүргэх үүргээ хэрэгжүүлэхэд анхаарч 2023 оны 2 дугаар улиралд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 20-50 цагаар илүү нэвтрүүлж, хамгийн өндөр хувийн өсөлт үзүүлсэн байна.

2022 оны 2 дугаар улиралд үндэсний түүх, соёл, уламжлалын нэвтрүүлэг бэлтгэн нэвтрүүлэх үүргийн хэрэгжилт 22%-тай буюу ердөө 4 телевиз шаардлага хангах хэмжээнд нэвтрүүлсэн бол 2023 оны 2 дугаар улиралд 9 телевиз шаардлага хангахуйц хэмжээнд нэвтрүүлсэн нь 55% болж өссөн байна.


#### Өргөн нэвтрүүлгийн телевизүүдээр 2023 оны хагас жилд нэвтрүүлсэн үндэсний түүх, соёл, уламжлалын нэвтрүүлгийн цагийг 2022 оны хагас жилийн цагтай харьцуулсан үзүүлэлт

Хүснэгт 4

Телевизион нэр	2022 хагас жил	2023 хагас жил
Central TV	184:44:07	124:27:14
Сүлд	120:39:30	122:42:00
Монгол HD	137:51:07	109:23:43
Боловсрол суваг	184:40:00	107:01:15
Стар ТВ	58:04:07	169:33:13
TB8	93:45:55	158:34:01
NTV	28:10:12	134:01:32
Малчин ТВ	46:51:38	121:14:12
TB9	22:42:57	104:40:35
ТМ	43:05:09	96:31:27
SBN	55:16:19	61:15:53
TenGer	7:11:50	58:18:52
TB5	26:06:12	57:16:39

ETB	48:45:50	21:33:41
25-р суваг	4:47:02	19:38:47
C1	6:13:21	13:38:16
UBS	29:34:31	9:35:23
Ийгл ньюс	2:50:19	0:48:03
<b>Нийт</b>	<b>1098:29:47</b>	<b>1490:14:46</b>

График 3



Улаанбаатар хотын өргөн нэвтрүүлгийн телевизүүдээр нэвтрүүлсэн үндэсний түүх, соёл, уламжлалын нэвтрүүлэг нэвтрүүлсэн үзүүлэлтийг 2022 оны хагас жил болон 2023 оны хагас жилийн нийлбэр дүнгээр харьцуулан Хүснэгт 4 болон График 3-д үзүүлээ.

Өргөн нэвтрүүлгийн 18 телевиз 2022 оны хагас жилд нийт 1098 цагийн үндэсний түүх, соёл, уламжлалын нэвтрүүлэг нэвтрүүлсэн 2023 оны хагас жилийн дүнгээр 1490 цаг нэвтрүүлсэн нь 35% өсөлттэй байгааг харж болно. Хэдийгээр Улаанбаатар хотын өргөн нэвтрүүлгийн телевизүүдийн 50 хувь нь “Телевизийн хөтөлбөрт тавигдах шаардлага”-аар хүлээсэн үндэсний түүх, соёл, уламжлалын нэвтрүүлэг нэвтрүүлэх үүргээ бүрэн биелүүлээгүй ч нийт дүнгээрээ өссөн үзүүлэлттэй байна.

Өргөн нэвтрүүлгийн тухай хууль батлагдаж, хуульд нийцүүлэн батлан гаргасан баримт бичгүүдийн хүрээнд Зохицуулах хорооноос телевизүүдэд байнгын хяналт, мониторингийн ажлыг хийж гүйцэтгэн, үндэсний түүх, соёл, уламжлалын нэвтрүүлгийн цагийг нэмэгдүүлж ажиллах талаар хугацаатай үүрэг даалгавар өгч ажиллаж байна.

Мониторингоор үндэсний түүх, соёл, уламжлалын нэвтрүүлгийн цагт үндэсний уламжлалт, түүх, соёлын өвийг тайлбарлан таниулсан баримтат бүтээл, нэвтрүүлгийг тооцдог юм.

--oOo--